



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/04

Улаанбаатар хот

2019 оныг “Иргэдийн оролцоотой
Үйлчилгээний чанарыг сайжруулах жил”
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 380 жил, нийслэлийн Тээврийн газар үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Нийслэлийн Тээврийн газрын Захиргааны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу 2019 оныг “Иргэдийн оролцоотой–Үйлчилгээний чанарыг сайжруулах жил” болгон зарласугай.

2. “Иргэдийн оролцоотой–Үйлчилгээний чанарыг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. “Иргэдийн оролцоотой–Үйлчилгээний чанарыг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлтэс, нэгжүүдийн саналыг тусган боловсруулж, Захиргааны зөвлөлийн хурлаар 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Мягмар/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, ажлын явц, үр дүнг улирал тутам дүгнэж, тайланг хагас, бүтэн жилээр Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Ц.Мягмар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР